



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2000 оны 04 дугаар
сарын 26-ны өдөр

№ 50

Улаанбаатар
хот

Сангийн дүрэм, хөрөнгө зарцуулах
журмыг шинэчлэн батлах тухай

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай Монгол улсын хуулийн дөрөвдүгээр бүлгийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Нийслэлийг хөгжүүлэх Улаанбаатар сан улсын үйлдвэрийн газрын дүрэм, сангийн хөрөнгийг зарцуулах журмыг шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1997 оны 2 дугаар тогтоолоор баталсан Улаанбаатар сангийн дүрэм, сангийн хөрөнгийг зарцуулах журмыг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-
ЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧ-
ДИЙН ДАРГА *Ц.Баасанжав*

Ц.БААСАНЖАВ

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-
ЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧ-
ДИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Г.Маналжав*

Г.МАНАЛЖАВ

ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮД :

Т.БИЛЭГТ

Э.ГОМБОЖАВ

С.МӨНХЖАРГАЛ

Б.НАМХАЙНЯМБУУ

Б.ӨЛЗИЙ

С.ПҮРЭВ

Ш.ТҮВДЭНДОРЖ

Нийслэлийг хөгжүүлэх "Улаанбаатар сан"-УҮГ-ын дүрэм

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нийслэлийг хөгжүүлэх "Улаанбаатар сан" улсын үйлдвэрийн газар нь / цаашид сан гэх / Монгол улсын Иргэний хууль, Компаний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийслэлийн эрхзүйн байдлын тухай хууль зэрэг холбогдох хууль, тогтоомж болон энэхүү дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулна.

1.2 Сан нь нийслэл Улаанбаатар хотыг хөгжүүлэх, түүний төсөв санхүүгийн чадамжийг нэмэгдүүлэх зорилготой, орон нутгийн өмч дээр үндэслэгдсэн Монгол улсын хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг, ганц гишүүнтэй, ашгийн төлөө хуулийн этгээд мөн.

1.3 Санг үүсгэн байгуулагч нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бөгөөд удирдах дээд байгууллага нь Удирдах Зөвлөл байна.

1.4 Удирдах Зөвлөлийн тоо, бүрэлдэхүүний саналаа Нийслэлийн Засаг дарга ИТХ-ын Тэргүүлэгчдэд оруулна.

1.5 Сангийн үйл ажиллагааг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаар батлагдсан 5-7 хүний бүрэлдэхүүнтэй Удирдах Зөвлөл / цаашид УЗ гэх / удирдана.

1.6 Сангийн тэргүүн нь Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч байна. Сан нь гүйцэтгэх захирал, ажлын албатай байна.

Хоёр. Сангийн оноосон нэр, оршин байгаа газар

2.1 Сангийн оноосон нэр нь Нийслэлийг хөгжүүлэх "Улаанбаатар сан" Улсын Үйлдвэрийн Газар байна.

2.2 Сангийн албан ёсны хаяг нь Улаанбаатар хот 46, Сүхбаатарын талбай 11, нийслэлийн төр захиргааны 1 дүгээр байр.

2.3 Сан нь өөрийн тамга, хэвлэмэл хуудас, данстай байна.

Гурав. Сангийн үйл ажиллагааны үндсэн чиглэл,

3.1 Сангийн эрхлэх үйл ажиллагааны үндсэн зорилт нь Нийслэл Улаанбаатар хотын эдийн засгийг хөгжүүлж, хүн амын ажиллаж амьдрах таатай бичил орчин бүрдүүлэхэд оршино

3.2 Сан нь дор дурдсан үйл ажиллагаа явуулна. Үүнд:

а. Хотын нийтийн аж ахуйг өргөтгөх, хүн амын үйлчилгээг нэмэгдүүлэх, нийгмийн асуудлыг сайжруулах, байгаль, экологийн таатай орчныг хамгаалах, бий болгох ажлыг санхүүжүүлэх

б. Хотын төсвийн ачааллыг багасгах зорилгоор эдийн засаг, санхүүгийн шинэ бүтцийг бий болгоход Монгол улсын хууль тогтоомжинд нийцүүлэн эх үүсвэр бүрдүүлэх, түүнд дэмжлэг үзүүлэх.

в. Гадаад болон дотоодын байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй гэрээ, хэлцэл байгуулах, Улаанбаатар хотын нэрэмжит гудамж талбай, цэцэрлэг бий болгуулах саналыг холбогдох газарт оруулах, хандив, дэмжлэг авах

- г. Нийслэл хотыг сурталчлах
- д. Хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа

Дөрөв. Сангийн хөрөнгийн эх үүсвэр.

- 4.1 Сан нь дор дурьдсан эх үүсвэрээс бүрдэнэ.
 - а. Дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс өргөсөн хандив, буцалтгүй тусламж,
 - б. Сангийн хөрөнгийг Монгол улсын хууль тогтоомжинд нийцүүлэн өөр байгууллагад байршуулснаас авах ногдол ашиг
 - в. Орон нутгийн өмчөөс орох орлого
 - г. Санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгийн орлого
 - д. Хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр

Тав. Сангийн Удирдах Зөвлөл

5.1 Сангийн эрх барих байгууллага нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаар батлагдсан Удирдах Зөвлөл байна. Удирдах Зөвлөлийн үйл ажиллагаа явуулах хэлбэр нь Удирдах Зөвлөлийн хурал байна.

5.2 Удирдах Зөвлөлийн дарга нь сангийн тэргүүн байна.

5.3 Удирдах Зөвлөлийн дарга, гишүүд дараах шаардлагыг хангасан байна.
Үүнд:

- а. Зээл болон батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй,
- б. Ял шийтгэлгүй
- в. Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь санг удирдахад харшлахгүй байх

5.4 Удирдах Зөвлөлийн гишүүд урамшуулалтай байна. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаар урамшлын хэмжээг тогтооно.

5.5 Удирдах Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа нь хоёр жил байх бөгөөд дуусгавар болгосон тохиолдолд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаар нөхөн батална.

5.6 Удирдах Зөвлөлийн ээлжит хурлыг улиралд нэгээс доошгүй удаа хийнэ.

5.7 Удирдах Зөвлөлийн ээлжит бус хурлыг Удирдах Зөвлөлийн дарга зарлан хуралдуулж болно.

5.8 Удирдах Зөвлөлийн гишүүдийн олонхи оролцсоноор Удирдах Зөвлөлийн ээлжит, ээлжит бус хурал хүчин төгөлдөр болж, оролцсон гишүүдийн олонхийн саналаар хурлын шийдвэр гарна.

5.9 Удирдах Зөвлөлийн шийдвэр нь тогтоол байна. Тогтоолд Удирдах Зөвлөлийн дарга, гишүүд гарын үсэг зурж, сангийн тэмдэг дарна.

5.10 Удирдах Зөвлөл нь дараах эрхтэй байна.

Үүнд:

- а. Сангийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг батлах,
- б. Сангийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц, захиргааны зардлын хэмжээг тогтоох
- в. Сангийн гүйцэтгэх захирлыг сонгож томилох, ажлаас нь чөлөөлөх, үйл ажиллагаанд нь хяналт тавих
- г. Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох цалин, шагнал, урамшуулал, өмч хөрөнгийг зарцуулах эрх хэмжээ, хариуцлагыг тогтоох,
- д. Сангаас үүсгэн санаачилж байгуулсан байгууллагын удирдлагыг томилох, дүрмийг батлах,

- е. Сангийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах
- ё. Бусад асуудал

Зургаа Сангийн тэргүүний эрх үүрэг.

6.1 Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс томилогдсон сангийн тэргүүн нь Сангийн дүрмийг баримтлан Сангийн үйл ажиллагааны хэтийн төлвийн чиг хандлагыг гаргаж, сангийн албаны ажиллах журмыг баталж мөрдүүлнэ.

6.2 Сангийн тэргүүн нь дор дурдсан үүргийг хүлээж эрх эдлэнэ. Үүнд:

- а. Удирдах Зөвлөлөөс баталсан зардлын хэмжээнд сангийн албаны орон тоо, цалин, тэтгэмж, хөнгөлөлт, урамшууллын хэмжээг тогтоож, ажилтныг ажилд томилох, ажлаас чөлөөлөх,
- б. Сангийн гүйцэтгэх захирлаар сонгож томилох хүний нэрийг Удирдах Зөвлөлийн хурал дээр дэвшүүлэх,
- в. Сангийн Удирдах Зөвлөл болон Хяналтын зөвлөлийн гишүүнд сонгох хүмүүсийг батлуулахаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд санал оруулах,
- г. Сангийн хөрөнгийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас баталсан журмыг үндэслэн гаргасан Сангийн Удирдах Зөвлөлийн шийдвэрийн дагуу захиран зарцуулж, гүйцэтгэлийн тайланг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнах,
- д. Шийдвэрээ тушаал гаргаж хэрэгжүүлэх
- е. Санг шинэчлэн өөрчлөх, татан буулгах асуудлын талаар санал боловсруулж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд оруулж шийдвэрлүүлэх,
- ё. Сангийн үйл ажиллагааны тайланг жил бүр Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд оруулж байх,

Долоо. Сангийн гүйцэтгэх захирлын эрх, үүрэг

7.1 Сангийн гүйцэтгэх удирдлагыг Удирдах Зөвлөлөөс сонгож, томилсон гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

7.2 Гүйцэтгэх захирал нь Сангийн дүрэм, Удирдах Зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулна.

7.3 Гүйцэтгэх захирал нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

- а. Өөрөө удирдах ёсны болон төр захиргаа, аж ахуйн байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан. Энэ салбарын удирдлагын ур чадвар, туршлагатай.
- б. Зээл болон батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй,
- в. Ял шийтгэлгүй,
- г. Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь санг удирдахад харшлахгүй байх,

Гүйцэтгэх захирал сонгогдож, томилогдсоноосоо хойш 7 хоногийн дотор гарын үсгийнхээ загварыг харилцагч банкны байгууллагад тэмдэглүүлнэ.

7.4 Гүйцэтгэх захирлын эдлэх эрх хэмжээг түүнтэй байгуулсан гэрээнд тодорхой тусгасан байна

7.5 Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаатай холбогдон үүссэн маргааныг шүүх хянан шийдвэрлэхэд Удирдах Зөвлөлөөс томилсон Удирдах Зөвлөлийн гишүүн Санг төлөөлөн оролцоно.

7.6 Гүйцэтгэх захирал нь энэхүү дүрэм, гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлээгүй, тэдгээрийг ноцтой зөрчсөн тохиолдолд Удирдах Зөвлөл гүйцэтгэх захирлыг ажлаас чөлөөлнө.

7.7 Гүйцэтгэх захирал нь дор дурдсан үүрэг хүлээж, эрх эдлэнэ.
Үүнд:

а. Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн хурлын шийдвэр, тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, түүний тамгын газраас өгсөн үүрэг даалгавар, Удирдах Зөвлөлийн шийдвэрийг биелүүлж, ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах,

б. Үүрэг гүйцэтгэх явцад олж авсан Нийслэлийн талаарх мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх,

в. Ажилтнуудын ажил, үүргийг сангийн тэргүүнтэй зөвшилцөж тогтоох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах

г. Олгогдсон эрх хэмжээний хүрээнд Сангийн тэргүүний зөвшөөрснөөр баталгаа, батлан даалт гаргах, гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурах,

д. Гүйцэтгэх захирал өөрийн эрх үүргийг итгэмжлэлийн үндсэн дээр холбогдох албан тушаалтанд шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

е. Бусад Аж Ахуйн Нэгж, байгууллагад хавсран ажиллахыг хориглоно.

Найм. Хяналтын Зөвлөл

8.1 Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаас 3 хүний бүрэлдэхүүнтэй Сангийн Хяналтын зөвлөл / цаашид ХЗ гэх/ -ийг байгуулна.

8.2 Хяналтын Зөвлөл нь Сангийн санхүү болон Удирдах Зөвлөл, гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд хяналт тавина.

8.3 Сангийн ажлын албаны ажилтан нь Хяналтын Зөвлөлийн гишүүн байж болохгүй.

8.4 Хяналтын Зөвлөлийн гишүүд дараах үүрэг хүлээж ажиллана. Үүнд:

а. Сангийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих,

б. Сангийн үйл ажиллагаа энэхүү дүрэмд нийцэж байгаа эсэхийг хянах,

в. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан тэнцэл гаргалт, татвар төлөлт, хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэхийг хянах,

Ес. Санхүү бүртгэл, тайлан

9.1 Сангийн санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргана.

9.2 Сангийн санхүүгийн тайлангийн үнэн зөвийг гүйцэтгэх захирал хариуцна.

9.3 Сан нь улсын татвар, нийгмийн даатгал үүнтэй адилтгах төлбөр тооцоог Нийслэлийн холбогдох байгууллагатай хийнэ.

9.4 Сангийн ногдол ашгийн хэмжээг Сангийн Удирдах Зөвлөл баталгаажуулна.

9.5 Сан нь хот нийтийн аж ахуйн тохижилт үйлчилгээнд гаргах хөрөнгийг холбогдох байгууллагатай байгуулсан гэрээний дагуу гаргана.

9.6 Сангийн санхүүгийн жил урьд оны 12 дугаар сарын 26-наас эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 25-наар дуусгавар болно.

9.7 Сан нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд жилийн үйл ажиллагаа, санхүү, хөрөнгийн талаар тайлангаа өгч байна. Тайланд дараах зүйлийг тусгана.

Үүнд:

- а. Тайлангийн хугацаанд Сангийн эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагаа, гарсан өөрчлөлт, үйл ажиллагааны үр дүн.
- б. Тайлангийн хугацааны удирдлагын зардлын хэмжээ
- в. Сангийн дүрмээр тогтоосон бусад мэдээлэл,
- г. Удирдах Зөвлөл нь Санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд оруулна.

Арав. Бусад зүйл

10.1 Монгол улсын Нийслэл Улаанбаатар хотыг хөгжүүлэх санд бодитой хувь нэмэр оруулсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд "Сангийн дэмжигч" гэсэн гэрчилгээг сангаас олгож, хандив өргөсөн иргэд, байгууллагын нэрийг ил тод байлгаж, Нийслэлд тэдний үйл ажиллагааны таатай нөхцлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.